



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

*Үндэсний аудитын газрын 2016 оны
бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан*

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН БАЙДАЛ



Тайланг бэлтгэсэн:

ААГ-ын ГА-ын баг

Тэргүүлэх аудиторын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Пүрэвсүрэн

Аудитын менежер
Ш.Ганчимэг

Ахлах аудитор
Ш.Мөнхбаяр

Шинжээч
С.Санжаажав
Г.Батмягмар

2016 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 7037-3089, 7037-8142
дугаарын утсаар харилцана уу.

ХАЯГ:

Аймгийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр 28 тоот
Дархан-Уул аймаг

Товчилсон үгийн жагсаалт 3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4

Бүлэг 1

Дархан-Уул аймгийн 26 багийн 53.8 хувь нь
Иргэдийн нийтийн хурлын ирцийн бүртгэл байхгүй байна
..... 5-8

Бүлэг 2

Тохижилтын ажлын ашиглалт, хамгаалалт
хангалтгүй байна9-12

Бүлэг 3

Аудитын явцад ААНБ-д өгсөн албан шаардлагыг
биелүүлж 12.7 сая төгрөгийн хөрөнгийг засварлаж,
шинээр хийж гүйцэтгэлээ.....13-19

Дүгнэлт 20

Зөвлөмж 20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газ
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ХАА	Худалдан авах алба
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТББ	Төрийн бус байгууллага
МУ	Монгол улс
ЗГ	Засгийн газар
УИХ	Улсын Их хурал
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2015 оны “Аудитыг сэдэв батлах тухай” 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2016 онд нийлүүлэх, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

ОНХС-ийн 2015 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг УИХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Хамарсан хүрээ

Аудитыг батлагдсан хуваарийн дагуу Орон нутгийн хөгжлийн санд 2015 онд улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан болон бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэнэ.

Арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нэгдсэн төсвийн тухай хууль
- УИХ, ЗГ-ын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан дүрэм, журам

Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг үзүүлэх нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

*Дархан-Уул аймгийн 26 багийн 53,8 хувь нь Иргэдийн
нийтийн хурлын ирцийн бүртгэл байхгүй байлаа*

1.1 Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Дархан-Уул аймгийн орон нутгийн хөгжлийн санд 6.7 тэрбум төгрөг хуваарилагдан батлагдсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн нэр төрөл, хэмжээг дотоодын НӨАТ-25 хувь 4.7 тэрбум, аймгаас төвлөрөх орлого 0.5 тэрбум, АМНАТХувиарлалт 1.1 тэрбум, газрын тосны НӨАТ 0.4 тэрбум төгрөг тус тус байхаар эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

УИХ-аас 2015 оны төсвийн тодотгол хийснийг үндэслэн Монгол Улсын Сангийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн төсвийн тодотголоор итгэлцүүрт үндэслэн хуваарилалт 3525.1 сая, аймгаас төвлөрөх орлого 723.1 сая, дотоодын НӨАТ-25 хувь 2424.7 сая, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хуваарилалт 716.5 сая нийт 4241.5 сая төгрөгийг аймгийн ОНХС-д олгохоор шийдвэрлэжээ.

Үүнд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэлбэлзэл, уул уурхайн үйлдвэрлэлээс шалтгаалан улс орны хэмжээнд эдийн засгийн тогтворгүй байдал бий болсноор арилжааны банкны зээлийн бодлого хумигдаж, хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан зэргээс шалтгаалан таамаглаж байсан эдийн засгийн өсөлт саарч төсвийн орлогын бүрдүүлэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй нь ОНХНС-аас орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүжилт дутагдахад нөлөөлсөн байна.

ОНХНС-аас Дархан-Уул аймагт 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилт дутуу ирсэн учир ажлын гүйцэтгэл нь баталгаажсан боловч эх үүсвэр дутагдсаны улмаас санхүүжүүлж чадаагүй төсөл, арга хэмжээ болон өмнөх оны дансны үлдэгдлийг 2015 оны орон нутгийн хөгжлийн санд тодотгол хийх замаар шийдвэрлэсэн байна.

1.2. Сумдын орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, татварын идэвхи санаачлага, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан, тооцоолж орлогын шилжүүлгийг хуваариласан нь Төсвийн тухай хуулийн 59.2 дахь заалтыг баримталсан байна.

Аймгийн Орон нутгийн ерөнхий дансны үлдэгдэл 2014 онд 2 970.8 сая, 2015 онд 2 051.6 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлж зарцуулалгүй, орон нутгийн хөрөнгө оруулалтанд зарцуулжээ.

ОНХС-аас орлогын шилжүүлгийг сумдад хуваарилсан тооцоог хүснэгтээр харуулав.

Сум	Хүн амын тоо	Хүн амын тооноос хамааруулан олгох дүн	Хүн амын нягтралын индекс	Нягтралаас хамаарсан	Алслалтын индекс	Алслалтаас хамаарсан	Газар нутаг км2	Газар нутгаас хамаарсан	Орлогын төлөвлөгөөний биелэлт	сая.төг	
										Татварын идэвх санаачлагаас хамааруулан олгох дүн	Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийн нийт дүн
Дархан сум	76248	691.5	779.1	0.6	0	-	98.1	8.5	0.2501	384.1	2,158.8
Орхон сум	3240	29.3	7.3	63.3	40	86.8	441.8	38.1	0.2731	146.4	427.1
Шарын гол сум	8121	73.5	85.0	5.5	70	151.9	95.5	8.2	0.3233	178.5	600.5
Хонгор сум	5759	52.1	2.2	212.8	20	43.4	2,639.5	227.4	0.1692	137.2	727.2
НИЙТ дүн	93548	846.4	873.6	282.1	130	282.1	3,274.9	282.1	1.0157	846.4	3,913.6

Дээрх тооцоонд сумдад олгох орлогын шилжүүлгийн дүнг 60 хувиар тооцжээ. Татварын идэвхи санаачилгын индексийг тооцоход үндэслэх мэдээлэл дутуу байсан тул татварын барагдуулалтанд үндэслэсэн үзүүлэлт, ИТХ-аар орлогын хувь хэмжээг тогтоосон үзүүлэлтийг адилхан авч, орлогын төлөвлөгөөний биелэлт татвар төлөгчийг татварт хамруулалтын үзүүлэлт зэргийг харгалзан үзэж гаргасан байна.

Төсвийн тухай хуулийн 59.2 **аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна** гэсэн заалтын дагуу ОНХС-аас олгосон шилжүүлгийн 60%-ийг Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу тооцон, сумдын орон нутгийн хөгжлийн санд дараах байдлаар хуваарилан аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11/05 тогтоолоор тодотгож баталсан байна.

№	Үзүүлэлт	Эхний батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү	Олгосон санхүүжилт
1	Аймгийн ОНХС	4 031,8	1 840,1	-2 191,7	1 289,0
2	Хонгор сумын ОНХС	471,3	379,8	-91,5	135,1
3	Шарын гол сумын ОНХС	399,2	421,0		297,4
4	Орхон сумын ОНХС	276,4	158,6	-117,8	151,4
5	Дархан сумын ОНХС	1 557,6	1 640,0		1 047,9
	Нийт дүн	6 736,3	4 439,6	-2 296,7	2 920,9

1.3. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого 2009-2021, аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дархан хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан байна.

Тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохдоо Сангийн сайдын 2014 оны 43, 2012 оны 244 дүгээр тушаал, хавсралтаар батлагдсан заавар, журам зэргийг баримтлахын зэрэгцээ иргэдээс санал авах, эрэмбэлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд: Дархан сум 7954, Хонгор сум 695, Шарын гол сум 704, Орхон сум 459 нийт 9812 иргэнээс санал авсан байна.

Аймаг, суманд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн урьдчилсан саналын жагсаалтыг Иргэний танхимын хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн иргэд, олон нийтээс хамгийн их санал авсан төсөл, арга хэмжээг эрэмбэлэх, эдгээрийг Засаг даргын мөрийн хөтөлбөр болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах, зэрэг ажлуудыг сумын болон багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэжээ.

1.4. “Дархан барилга захиалагч” ОНӨААТҮГ орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн барилга байгууламж барих, засварлах, шинэчлэх, өргөтгөх ажлуудад зарцуулах хөрөнгө, төсөвт өртгийг урьдчилан тооцсон, ТЭЗҮ, зураг төсвийг батлуулж зохих ёсоор бүрдүүлж эхлүүлэх, гүйцэтгэх явцад батлагдсан зураг төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж гүйцэтгэлийг баталгаажуулж ажилласан байна.

1.5. Баг хорооны Нийтийн хурлыг Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23,10 дахь **“баг хорооны хуралдаан зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно”** гэсэн заалтыг Дархан сумын 12, Хонгор сумын 1, Шарын гол сумын Хайрхан, Санжинт, Дархан багууд тус бүр зөрчиж иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулсан байна. Хүснэгтээр харуулбал:

№	Баг	Хурлын бүртгэл	Багийн иргэд	Өрхийн тоо	Хуралд оролцсон иргэн	Оролцох ёстой иргэн	Санал авах маягт	Тайлбар
							Аудитаар	
1	I	Байхгүй	4172	1143	49	38	1196	
2	II	Байхгүй	4528	1390	62	46	712	

3	III	Байгаа	5608	1609	81	54		Албан шаардлага
4	IV	Байхгүй	3485	1122	46	37	131	
5	V	Байгаа	4995	1451	77	48	220	
6	VI	Байхгүй	5234	1462	128	49	479	
7	VII	Байхгүй	5995	1662	83	55	780	
8	VIII	Байгаа	6978	2032	64	68	522	
9	XI	Байгаа	5059	1414	56	47	491	
10	X	Байхгүй	5169	1578	197	53	326	
11	XI	Байхгүй	3778	1170	45	39	291	
12	XII	Байгаа	3905	1191	36	40	281	Хүчингүй хурал
13	XIII	Байхгүй	4180	1198	61	40	541	
14	XIV	Байгаа	4079	1190	55	40	466	
15	XV	Байгаа	7947	2553	126	85	795	
16	XVI	Байгаа	4067	1363	51	45	430	
17	Өргөө	Байхгүй	3578	1033	30	34	155	
18	Малчин	Байхгүй	1873	610	36	20	138	
19	Хонгор I	Байхгүй	2561	584	57	146	102	Хүчингүй хурал
20	Хонгор II	Байхгүй	1756	481	159	120	277	
21	Хонгор III	Байгаа	1784	522	152	130	316	
22	ШГ Санжинт	Байгаа	2691	707	78	177	270	Хүчингүй хурал
23	ШГ Дархан	Байгаа	2291	587	43	147	174	Хүчингүй хурал
24	ШГ хайрхан	Байгаа	3169	913	68	228	260	Хүчингүй хурал
25	Ор Баян-өлзийт	Байхгүй	2535	704	214	176	248	
26	Ор. Энхтал	Байхгүй	620	230	198	57	211	

Дархан сумын 3 дугаар багийн Засаг даргад Хуралд оролцсон иргэдийн бүртгэл, ОНХСанд иргэдээс санал авсан маягтыг шаардсан хугацаанд гаргаж ирүүлээгүй тул Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйл 28.1-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах **АЛБАН ШААРДЛАГА** хүргүүлэв.

Дархан-Уул аймгийн 26 багийн 53,8 хувь нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд олон нийтээс санал авсан Иргэдийн нийтийн хурлын ирцийн бүртгэл байхгүй байна.

Бүлэг 2

*Тохижилтын ажлын ашиглалт, хамгаалалт
хангалтгүй байна.*

2.1. Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг:

- Импортоос бусад бараа ажил үйлчилгээний НӨАТ-ын орлогын 25 хувь
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5.0 хувь
- Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж хандив
- Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг доод шатны төсөвт үлдээн, үлдэх хэсгийг төсөвт төвлөрүүлсэн зэрэг орлогоор бүрдүүлэхээр хуульчилсан.

2015 онд орон нутгийг дэмжиж хандив өгсөн гадаад, дотоодын байгууллага байхгүй байна.

Дархан-Уул аймгийн улсын төсөв, Хүний хөгжил санд 2015 онд төвлөрүүлэх татварын орлогыг Татварын ерөнхий газрын даргын 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/220 дугаар тушаалаар ААНБОАТатвар 1200.0 сая, НӨАТ 2950.0 сая, ОАТ 36.8 сая, агаарын бохирдлын төлбөр 44.0 сая, АМНАТ 345.0 сая нийт 4575,8 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

Дархан-Уул аймгаас улсын төсөв, Хүний хөгжил санд 2015 онд төвлөрүүлэх татварын орлогод ААНБОАТатвар 1425.7 сая, НӨАТ 2464.7 сая, ОАТ 54.5 сая, агаарын бохирдлын төлбөр 39.9 сая, АМНАТ 635.3 сая нийт 4620.2 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 44.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хийгдэх ажил, үйлчилгээг МУ-ын ЗГ-ын Худалдан авах ажиллагааны e-procurement.mof.gov.mn, Худалдан авах ажиллагааны e-tender.mn, цахим тендерийн meps.gov.mn, аймгийн ЗДТГ-ын e-darkhan.gov.mn, аймгийн Худалдан авах ажиллагааны e-tender.da.gov.mn сайтуудад байрлуулж, мөн үндэсний хэмжээний өдөр тутмын “Өдрийн сонин”, “Монголын үнэн” сонинуудад тухай бүр мэдээлсэн байна.

Сангийн сайдын 2012 оны 301 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн, үнэлгээний хороонд ажиллах эрх олгох сургалтанд хамрагдаж А-3 сертификат авсан төрийн албан хаагчид болон иргэдийн төлөөллийг оролцуулан 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулсан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны алба нь 2015 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2.1 тэрбум төгрөгийн 21 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж засвар шинэтгэлийн ажилд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөгө болгон ажиллажээ.

Аймгийн ХАА-ны алба нь 2015 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар 10, харьцуулалтын аргаар 10, бага үнийн аргаар 1 нийт 21 төсөл, хөтөлбөрт сонгон шалгаруулалт явуулжээ.

2015 оны ОНХНС-д хасах тодотгол хийгдсэн тул сонгон шалгаруулалтаар Дархан сумын 6, 7, 15 дугаар багуудад хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг “Мөнх од цацрал” ХХК, 6 дугаар багийн явган хүний зам тохижилтын ажлыг “Тэтү” ХХК, Шарын гол сумын явган хүний замын ажлыг “Мөнх од цацрал” ХХК гүйцэтгэх гэрээ байгуулсан төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх боломжгүй гэсэн шалтгаанаар царцаасан байна.

Аймгийн Засаг дарга Үнэлгээний хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил гүйцэтгэх гэрээг тендерт шалгарсан гүйцэтгэгч аж ахуй нэгж, байгуулагуудтай байгуулжээ.

Аудитын явцад тендер шалгаруулалтын баримт материалыг шалгахад Дархан сумын 10-р багт “Жишиг хороолол-3” төслийн хүрээнд тоглоомын талбай, гэрэлтүүлэгийн ажил, Дархан сумын 9-р багт авто зогсоол, замын өргөтгөлийн ажил, 9-р баг 31 дүгээр хорооллын цэвэр ус ариутгал татуурга цахилгаан хангамжийн ажил, 6, 7, 15 дугаар багуудад хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлууд Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, дүгнэлтэд гарын үсэг дутуу зурагдсан алдаа, зөрчилтэй байлаа.

Дархан сумын 8, 15 дугаар багт гэр хорооллын гэрэлтүүлгийн ажлын тендерт “Орхон тек” ХХК-нийг шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэрд “РЗА” ХХК гомдол

гаргасаныг Сангийн яам хянаж үзээд тендерээс татгалзсан үндсэлтэй харин “Нэксткүүлэр” ХХК-аас тодруулга авсны үндсэн дээр үнэлгээ хийж шийдвэрлэх шаардлагатай гэж мэдэгдсэн. Тодруулгаар нотлогдоогүй тул үнэлгээний хорооны гишүүд өмнөх шийдвэр хүчинтэй гэж үзсэн байв.

Мөн Дархан сумын 1, 2, 3, 6, 7, 13, 15, Малчин багуудад “Хаягжилт төсөл”-ийн ажлын тендерт оролцогч “И энд Би Би” ХХК-иас гомдол гаргасаныг Сангийн яам хянаж үзээд захиалагчийн зүгээс тендерт оролцогч “И энд Би Би” ХХК-ны ирүүлсэн тендерийн материалыг дахин шийдвэрлэх үндсэлтэй гэж албан бичгийн дагуу дахин үнэлгээ хийж өмнө нь гаргасан үнэлгээний хорооны шийдвэр нь хүчинтэй гэж шийдвэрлэсэн байна.

Дархан сумын 11 дүгээр багт “Камержуулалт төсөл”-ийн ажил гүйцэтгэх тендерт оролцогч “И энд Би Би” ХХК-иас гомдол гаргасаныг Сангийн яам хянаж үзээд захиалагчийн зүгээс тендерт оролцогч “И энд Би Би” ХХК-ны ирүүлсэн тендерийн материалыг дахин шийдвэрлэх үндсэлтэй гэж албан бичгийн дагуу дахин үнэлгээ хийж өмнө нь гаргасан үнэлгээний хорооны шийдвэр нь хүчинтэй гэж шийдвэрлэжээ.

2.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг эзэнжүүлэх, бүртгэлжүүлэх ажлыг аймгийн ИТХ-ын дэргэдэх Өмчийн алба, Хөгжлийн бодлогын хэлтэс хамтарч зохион байгуулж, тухайн төсөл арга хэмжээ, барилга байгууламжийг хүлээн авах ажлын комисст ашиглагч байгууллагын төлөөлөл болох дарга, нягтлан бодогч нарыг оролцуулсан байна. Төсвийн жилд багтааж тухайн байгууллагын тайлан балансад бүртгэх ажлыг төсвийн гүйцэтгэлийн тойрох хуудсаар баталгаажуулж бүртгэжээ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д **Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана** гэсэн заалтын дагуу Жишиг хороолол, хүүхдийн тоглоомын талбай, гэрэлтүүлгийн ажлыг НААҮГазар, Авьяас, Ном хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлыг БСГ болон сургууль, цэцэрлэгт гэх мэтчилэнгээр ашиглагч байгууллагууд бүртгэл тайландаа тусган, бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа ч тохижилтын ажлын ашиглалт, хамгаалалт хангалтгүй байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 309 тоот захирамжаар өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр үйлчлэх хүрээ, хийц бүтээц, зориулалтаас нь хамааруулан барилга байгууламж, бүх төрлийн барилга

байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт, их засварыг хүлээн авч байнгын ашиглалтанд оруулах чиг үүрэг бүхий комиссын бүрэлдэхүүнийг баталсан байна.

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйл, Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 309 тоот захирамжийг үндэслэн ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хийгдэх хөрөнгө оруулалтыг хүлээн авах ажлыг Хөгжлийн бодлогын хэлтсийн хөрөнгө оруулалтын бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан ажиллажээ.

Мөн Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 290 тоот тушаалаар батлагдсан дараах хавсралтуудыг мөрдлөг болгон ажилласан байна.

- Барилга угсралт, их засварын ажлын хяналтын хүснэгт /хавсралт №1/
- Тоног төхөөрөмжийн хяналтын хуудас /хавсралт №2/
- Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл /хавсралт №3/
- Их засварын ажлын үе шатны ажлын хуваарь /хавсралт №4/
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилгын ажлын гүйцэтгэл /хавсралт №5/
- Тоног төхөөрөмжийг хүлээн авсан комиссын акт /хавсралт №6/
- Ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг /хавсралт №7/

Бүлэг 3

*Аудитын явцад ААНБ-д өгсөн албан шаардлагыг
биелүүлж 12,7 сая төгрөгийн хөрөнгийг засварлаж,
шинээр хийж гүйцэтгэлээ*

3.1. Аймгийн ИТХТ-ийн 2012 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 97 тоот тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэж буй барилга байгууламж барих, засварлах, шинэчлэх, өргөтгөх ажлыг эхлүүлэх, гүйцэтгэх явцад технологийн хяналт тавьж, гүйцэтгэлийг баталгаажуулах, барилга байгууламжийг хугацаанд нь ашиглалтанд хүлээлгэн өгөх ажлыг сайжруулах зорилгоор “Дархан барилга захиалагч” ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

Тус алба захиалагчийн хяналтыг Иргэний хууль, Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгож, барилгын үе шатны ажилд хяналт тавьж, ашиглалтанд оруулжээ.

Захиалагчтай байгуулсан гэрээний дагуу тухайн ажлыг гүйцэтгэгчтэй “Барилга захиалагч” ОНӨААТҮГ техник хяналтын гэрээг байгуулан үе шатны санхүүжилт, гүйцэтгэгчийн ажлын явц, чанарт хяналт хийж, холбогдох акт баримт, ажлын тэмдэглэл илд далд ажлыг фото зургаар баталгаажуулсан байна.

Аудитын явцад Дархан-Уул аймагт хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлийг газар дээр нь шалгаж, гэрээний батгалгаат хугацаанд эвдрэл гэмтэл гарсан хэсгийг дахин хийлгэх тухай **АЛБАН ШААРДЛАГА**-ыг дараах байгууллагуудад хүргүүлж 12.7 сая төгрөгийн хөрөнгийг засварлаж зарим ажлыг шинээр хийлгүүлэв.

№	Дугаар	Байгууллага	Утга	Гүйцэтгэгч	Зардал	Биелэлт
1	01/09	Дархан сум	3-р багийн Засаг дарга Д.Туяа сахилгын шийтгэл			2016.03.25
2	03/15	ХБХ	Хогийн 2ш сав эвдэрсэн	“Мөнх наран сүлд” ХХК	280,000	2016.04.20
3	02/14	Дархан сум	Сүүдрэвчийн ширээ. №3	“Дархан Хөлөг” ХХК	300,000	2016.04.20
4		Дархан сум	Хогийн сав №2	“Дархан Хөлөг” ХХК	160,000	2016.04.20
5		Дархан сум	Эргэдэг тоглоом №1	“Дархан Хөлөг” ХХК	1,000,000	2016.04.20
6		Дархан сум	Хогийн сав 4ш. №4	“Дархан Хөлөг” ХХК	640,000	2016.04.20
7	04/16	Дархан сум	Гэрлийн шон далийсан	“Хатуу төмөр” ХХК	300,000	2016,04,20
8		Дархан сум	1 ш сандал дутуу	“Хатуу төмөр” ХХК	140.000	2016,04,20
9		Дархан сум	6 ш гэрэл дутуу	“Хатуу төмөр” ХХК	1.500.000	2016,04,20
10		Дархан сум	Эргэдэг тоглоом эвдэрсэн	“Хатуу төмөр” ХХК	800.000	2016,04,20
11		Дархан сум	Хогийн сав эвдэрсэн	“Хатуу төмөр” ХХК	100.000	2016,04,20
12	01/18	ХБХ	8 ш сандал дутуу	“Мөнх наран сүлд” ХХК	960,000	

13	05/17	НБХ	264 ш ном хийгдээгүй байгаа	18-р цэцэрлэг	1.000.000	2016.03.30
14	06/18	НБХ	Хамгийн сайхан хот дуу	15-р сургууль	500.000	2016,04,20
15		НБХ	Хүүхэд хөгжил авьяас	"Гал гурван шагай" ХХК	1.000.000	2016,04,20
16		НБХ	Өсвөр үе хөгжил төв	Чөлөөт бүжгийн холбоо	1.000.000	2016,04,20
17	01/13	Орхон сум	Цэцэрлэгийн дээврийн дулаалга	"Дархан Хөлөг" ХХК	3.985.000	2016,04,20
Нийт					12.705.000	

Мөн Дархан сумын 10 дугаар багт Жишиг хороолол-3 төслийн хүрээнд явган замын тохижилтыг хийж гүйцэтгэсэн "Мөнх нарны сүлд" ХХК уг ажлыг 2015 оны 08 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтанд оруулахаар гэрээ байгуулсан боловч аудитаар 8 ширхэг сандлыг дутуу гүйцэтгэж ашиглалтанд оруулаагүй нь Иргэний хуулийн 350.1.1-д **"гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх"** гэж заасныг зөрчсөн тул 960.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Дархан суманд ОНХС-ийн хөрөнгөөр гэр хороолол доторх 0,271 км зам засварын ажлыг "Өсөх Урам" ХХК 166,5 сая төгрөгөөр хийхээр шалгарч 2015 оны 07 дугаар сарын 09-ны өдөр гэрээ байгуулсан боловч Авто замын трасад замын хажуу талын айл, өрхүүдийн хашааг зөвшөөрөлгүй сунгаснаар зураг төсвийн дагуу авто замын засвар шинэчлэлтийн ажлыг хийх боломжгүй болгож, уг ажил хугацаандаа хийгдэж дуусаагүй байна.

Дархан сумын 1 дүгээр багийн удирдлагууд газар дээр нь очиж танилцаад айл өрхүүдийг зөвшөөрөлгүй сунгасан хашаагаа чөлөөлж өгөхийг хүссэн боловч айл, өрхүүд ГХБХБГ-аас газар өмчилөх гэрчилгээг авсан байсан тул нөхөн олговор шаардаж, хоорондын асуудалд үл ойлголцол бий болж уг ажилд хийгдэхгүйд хүрсэн байна.

Жишиг хороолол-3 төслийн хүрээнд Дархан сумын 10-р багт "Дархан Хөлөг" ХХК-ны хийж гүйцэтгэсэн тохижилтын ажлаас сүүдрэвчийн ширээ, хогийн сав, эргэдэг тоглоом, гэрлийн шон эвдэрсэн, "Мөнх нарны сүлд" ХХК-ны явган замын тохижилтын ажлын 2 ширхэг хогийн сав гэрээнд заасан баталгаат хугацаанд эвдэрч гэмтсэн тул албан шаардлага хүргүүлж, засууллаа.

Мөн Дархан сумын 9-р багт "Хатуу төмөр" ХХК-ны гүйцэтгэсэн ажлаас 6 ширхэг гэрэлтүүлэг, сандал, хогийн сав, эргэдэг тоглоом, гэрлийн шонг тус тус засварлаж ашиглалтанд оруулах албан шаардлагыг хүргүүлсэн.

Орхон сумын Шар дэрсний гэр цэцэрлэгийн барилгажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн "Дархан Хөлөг" ХХК-д дээврийн дулаалгын ажлыг дахин хийлгэж шаардлагатай тул албан шаардлагыг хүргүүлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 оны аймгийн хөтөлбөрүүдийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд 41.5 сая төгрөгийг төлөвлөлж, 34.5 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 43 тоот тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 4.5-д **Орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх** гэсэн заалтыг зөрчин дараах байгууллагуудад санхүүжилт олгосон байна.

№	Байгууллага	Төслийн нэр	Гэрээний дүн	мян.төг
				Авсан санхүүжилт
1	“Иргэний нийгэм нэгдсэн зөвлөл” ТББ	Төр хувийн түншлэл	10000,0	4000,0
2	“Хурд, хүч, хөдөлгөөн, хөгжил” ТББ	Спортлог амьдарцгаая сарын аян	3550,0	3550,0
3	Морин хуурын төв	Хуураан эгшиглүүлье	4000,0	4000,0
4	Цэцэрлэгийн эрхлэгчдийн холбоо	Хөгжилтэй аялгуу хэмнэл	1350,0	1350,0
5	Тулах цэг мэдээллийн төв	Хүүхдийн найрал дууны хамтлаг	1500,0	1500,0
6	“Гал гурван шагай” ТББ	Хүүхдийн хөгжил авьяас	1000,0	1000,0
7	Дархан чөлөөт бүжгийн холбоо	Өсвөр үе хөгжил	1000,0	1000,0
8	“Мон студи” ТББ	Өсвөрийн сэтгүүлч	1000,0	1000,0
ДҮН			23400,0	17400,0

Дээрх төслүүдийг аудитын явцад очиж шалгахад “Тулах цэг мэдээллийн төв” 1,5 сая төгрөгийн санхүүжилтээр Найрал дууны хамтлагийн 150 хүүхдийн хувцасны материал худалдан авсан, “Морин хуурын төв” ТББ 4.0 сая төгрөгөөр хөгжмийн зэмсэг худалдан авсан, “Цэцэрлэгийн эрхлэгчдийн холбоо” 1,3 сая төгрөгөөр кислупон хөгжим худалдан авч цэцэрлэгүүдэд тараасан, “Хурд, хүч, хөдөлгөөн, хөгжил” ТББ хороололын аварга шалгаруулах спортын арга хэмжээг 3,5 сая төгрөгөөр зохион байгуулсан, “Иргэний нийгмийн нэгдсэн зөвлөл” ТББ Нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхийн тулд ИНБ-уудын зүгээс мониторинг хийх замаар орон нутгийн төр, бизнес, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлийг сайжруулах талаар аймгийн Засаг даргатай “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 4,0 сая төгрөгийг санхүүжилт авч ажилласан байсан.

Харин “Гал гурван шагай” ТББ 1.0 сая, “Дархан чөлөөт бүжгийн холбоо” 1.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байгууллагууд аудитын явцад үйл ажиллагаа явуулах байр байхгүй улмаас төсөл, хөтөлбөр хэрэгжих боломжгүй байгаа гэсэн тайлбарыг өгсөнд албан шаардлага хүргүүлэн дээрх 2 төслийг хэрэгжүүлж эхлүүллээ.

ОНХС-ийн зааврын 4.6-д **ОНХС-ийн хөрөнгийг буцалтгүй тусламж дэмжлэгэд зарцуулахгүй байх** гэсэн заалтуудыг зөрчин Авьяас дэд хөтөлбөрийн хүрээнд 2014-2015 оны хичээлийн жилийн улсын төрөлжсөн олимпиадад оролцож медаль авсан багш, сурагчдад 3.4 сая, “Ном” хөтөлбөрийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн

ажилдаа өндөр амжилт үзүүлж хичээл зүтгэл гарган ажилласан тул 12 багш, ажилтанд 0.6 сая төгрөгийн урамшуулал тус тус олгосон байна.

Тус зааврын 4.8-д **ОНХС-аас санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй давхардуулахгүй байх** гэсэн заалтыг мөн зөрчсөн байна. Хүснэгтээр харуулбал.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Гүйцэтгэгч	Эхлэх дуусах хугацаа	Гэрээн ий дүн	Үүнээс санхүүжих дүн			
					ОНХС	АТХО	ЗАМЫН САН	Шилжих Хө.ор
1	Хуучин шинэ Дарханыг холбосон 2,48 км авто замын барилга угсралтын ажил	Өсөх урам ХХК	2015	6 293,3	477,1	1 499,5	117,6	243,7
2	Машины зогсоол байгуулах ажил 10-р багт	"Дархан хөлөг" ХХК	2015	246,8	188,9	57,9		
3	13-р цэцэрлэгийн Ширээ нуруун дахь салбар цэцэрлэгийн гадна цахилгаан, бохирын систем	Бор божуу ХХК	2015	71,0	9,0	62,0		
4	Жишиг хороолол-3 /9, 10-р баг/	"Дархан хясаат" ХХК	2015	223,6	50,0	173,7		
		"Дархан хөлөг" ХХК		135,8	40,0	95,9		
		"Хатуу төмөр" ХХК		203,4	50,0	153,4		
Дүн				887,2	815,0	2 042,4		

Төсвийн тухай хуулийн 60.3.3-т Үндэсний их баяр наадамд ОНХС-аас хөрөнгө зарцуулахыг хориглоогүй боловч МУ-ын ЗГ-ын 2010 оны 271 дүгээр тогтоолд энэ арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 сая, суманд 5.0 сая төгрөгөөр тогтоосон байгааг баримтлах нь зүйтэй гэж заасныг хэрэгжүүлэхгүй Үндэсний баяр наадмын зардалд аймгийн ЗДТГ 30.0 сая, Шарын гол сумын ЗДТГ 10.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Иймд цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр арга хэмжээнүүд нь олон иргэдийн санал авч дэмжигдэж байгаа ч олон талын хүчин зүйлийг харгалзан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг байгуулж байхгүй бол төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байгааг анхаарах хэрэгтэй.

3.2. 2015 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээг Сар болгон шинэчлэж, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад олгох бүрт шинэчилж аймгийн Засаг даргын тамгын газрын Ил тод мэдээллийн самбарт байршуулж ажилласан байна.

Мөн 18-н багийн иргэдийн нийтийн 32 удаагийн хуралд бүтээн байгуулалтын 2014, 2015 оны ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг танилцуулж, 2015 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн бүтээн байгуулалтын ажлыг дүгнэжээ.

ОНХСангийн гүйцэтгэл 98,0 хувийн, Улсын төсвөөс орон нутагт эрх шилжсэн 130.6 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ 100 хувь, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээ 98.5 хувьтай хийж гүйцэтгэсэн байна.

2015 онд Аймгийн ИТХурлын тэргүүлэгчдын хуралдаан, Засаг даргын зөвлөлийн хуралд 2015 онд хэрэгжүүлсэн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг 1 удаа, ИТХуралдаанаар 1 удаа, ИТХ-ын дэргэдэх иргэний танхимаар 3 удаа гүйцэтгэлийн тайланг танилцуулж, Шилэн данс, Darkhan.gov.mn. мөн орон нутгийн ЛХА, DBS телевизүүдээр санхүүжилтийг хэрхэн олгож байгаа талаар ард иргэдэд мэдээлжээ.



Хуулийн хүрээнд 2015 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 2920.9 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллага аж ахуйн нэгжид олгосон талаархи мэдээллийг дээрхи сайтуудад байршуулсан байна.


Сангийн Яамнаас аймгийн ОНХС-ийн 2015 оны орлогын шилжүүлгээр 3733.9 сая төгрөг санхүүжүүлснээс ААНБ-д 2920.9 сая төгрөг олгож ОНХС-ийн дансанд 812,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дархан-Уул аймагт 2013 оноос одоог хүртэл аж ахуйн нэгж байгууллагад өгөх өглөг 400.6 сая төгрөг болжээ.

Аймгийн Засаг даргад Монгол Улсын Сангийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 4-4/1002 албан бичгээр ОНХС-ийн зарим эх үүсвэр тухайлбал Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.4 дэх хэсэгт заасан эх үүсвэр 40 хувь, газрын тосны НӨАТ-ийн орлого 43 хувиар тус тус тасарсан, улсын төсөв хүндэрсэн зэргээс шалтгаалан 2015 оны ОНХС-ийн үлдэгдэл санхүүжилтийг олгох боломжгүй байна.

Иймд аймаг, нийслэлийн ОНХС-ийн 2016 оны төсөвтөө тодотгол хийж, өмнөх онуудад хийгдсэн ажлуудын дутуу санхүүжилтийг урьдчилан шийдэж иргэд, аж, ахуйн нэгжийн өр авлагыг барагдуулж ажиллана уу гэжээ.

ОНХНС-аас олгох санхүүжилтийн үлдэгдэл 694,2 сая, дансанд байгаа зарцуулаагүй үлдэгдэл 812,9 сая төгрөгийг Сангийн сайдын 4-4/1002 албан бичгийг үндэслэн аймгийн ОНХС-д тодотгол хийх боломжгүй юм. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-д **дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон тохиолдолд** иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд аймгийн Засаг дарга өргөн мэдүүлснээр тухайн жилийн төсөвт тодотгол хийгдэх ёстой. Улсын төсвийн ОНХНС-д 2016 оны төсөвт тодотгол суугдаагүй буюу тусгагдаагүй тохиолдолд аймгийн ИТХТ-ийн хурлаар тодотгол хийх боломжгүй юм.

Дархан-Уул аймагт 2013 оноос ААНБ-д өгөх санхүүжилт 883.9 сая төгрөг болжээ. Үүнээс гүйцэтгэлээс хэмнэгдсэн 290.9 сая, магадлашгүй ажлын 73.9 сая, зураг төсвийн үнэ 111.5 сая, алданги 6.9 сая нийт 483.3 сая төгрөгийг суутгаж ААНБ-д өгөх өглөг 400.6 сая төгрөг байна.



Дээрх графикаас харахад ОНХНС-аас 2015 онд олгосон санхүүжилтийг ОНХС-аас 2013 оны шилжих хөрөнгө оруулалтанд 89.9 сая, 2014 оны ажлын гүйцэтгэл нь дууссан хөрөнгө оруулалтанд 1612,8 сая төгрөгийг тус тус санхүүжүүлж, 2015 оны ОНХС-ийн шинээр эхлэх хөрөнгө оруулалтанд 1114,5 сая, их засварын ажилд 20,0 сая, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд 83,7 сая нийт 2920,9 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.3. ОНХС-ийн 2014 оны зарцуулалтад хийсэн Нийцлийн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд иргэдийн саналыг хангалттай тусгаж чадаагүй байна гэсэн дүгнэлтийг өгсөн байна.

Тухай үеийн аймгийн Засаг дарга С.Насанбатад дараах зөвлөмжүүдийг хүргүүлжээ.

1. Сум, багийн ИНХ-ын ирцийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулж байх.

2. ОНХС-ийн төсвийн төсөлд аймгийн Аудитын газраас оруулсан саналыг авч хэрэгжүүлж байх.
3. Төсвийн тухай хуулийн 60.3.1 дэх заалт, Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн заавар, МУ-ын ЗГ-ын 2010 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- 2015 онд Дархан-Уул аймгийн 26 багийн 53,8 хувь нь Иргэдийн нийтийн хурлын ирцийн бүртгэл байхгүй байна.
- Монгол Улсын төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтыг үндэслэн Шарын гол сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтаас улсын баяр наадмын зардал 10.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 5.0 сая төгрөгийг хасах санал хүргүүлснийг хасаагүй.
- Аймгийн Засаг дарга С.Насанбатад ОНХС-аас зарцуулахаар тооцсон улсын баяр наадмын 30.0 сая, төсөл, хөтөлбөрүүдийн зорилтыг хэрэгжүүлэх зардлаас 50.0 сая төгрөгийг тус тус хасах санал оруулсан ч хэрэгжүүлж ажиллаагүй.
- Төсвийн тухай хуулийн 60.3.3-т Үндэсний их баяр наадамд ОНХС-аас хөрөнгө зарцуулахыг хориглоогүй боловч МУ-ын ЗГ-ын 2010 оны 271 дүгээр тогтоолд энэ арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 сая, суманд 5.0 сая төгрөгөөр тогтоосон байгааг баримтлах нь зүйтэй гэж заасныг хэрэгжүүлэхгүй Үндэсний баяр наадмын зардалд аймгийн ЗДТГ 30.0 сая, Шарын гол сумын ЗДТГ 10.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Мөн 2014 ОНХС-ийн зарцуулалтын байдалд хийсэн нийцлийн аудитын явцад аж ахуйн нэгж байгууллагууд өгсөн албан шаардлагын биелүүлж 15.8 сая төгрөгийн хөрөнгийг засварлаж, шинээр хийлгэж, Хонгор суманд хүүхдийн тоглоомын талбай барьж байгуулсан “Ган Зосон” ХХК 918.0 мянган төгрөгийн материалын зардлыг нэмэгдүүлэн тооцож, санхүүжилт илүү авсан зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоож, барагдуулсан.

ДҮГНЭЛТ

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд иргэдийн саналыг хангалттай тусгаж чадаагүй, хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилтын ажлын ашиглалт муу байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга А.Энхболдод:

1. Сангийн Сайдын 2014 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 43 тоот тушаалаар батлагдсан ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зааврын 4 дүгээр зүйлийн 4.5, 4.6, 4.8 дахь заалтуудыг мөрдлөг болгон ажиллах
2. Сум, багийн Иргэдийн нийтийн хурлын ирцийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулж байх. (Хуралд ирсэн иргэдийн гарын үсэг)
3. ОНХС-ийн төсвийн төсөлд Монгол Улсын төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтыг үндэслэн аймгийн Аудитын газраас оруулсан саналыг хэрэгжүүлж ажиллах
4. Төсвийн тухай хуулийн 60.3.1 дэх заалт, Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 43 тоот тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн заавар, МУ-ын ЗГ-ын 2010 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах
5. “Шилэн дансны тухай” хуулийг хэрэгжүүлж ажиллах

ТАЙЛАНГ ХЯНАСАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ш.ГАНЧИМЭГ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

**АХЛАХ АУДИТОР
ШИНЖЭЭЧ**

**Ш.МӨНХБАЯР
С.САНЖААЖАВ
Г.БАТМЯГМАР**